



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 35

Мандалговь

“Үл хөдлөх хөрөнгөд үнэлгээ тогтоож, худалдах,  
акталж данснаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Дундговь аймгийн Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 868,632 /найман зуун жаран найман мянга зургаан зуун гучин хоёр/ төгрөгийн балансын үнэтэй, 700,797 /долоон зуун мянган долоон зуун ерэн долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, аж ахуйн хашааны худалдах доод үнийг 250,000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгөөр, хоёр модон складын худалдах доод үнийг тус бүрийг нь 350,000 /гурван зуун тавин мянга/ төгрөгөөр хавсралтын дагуу тогтоон дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Дэрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал (Д.Мөнхтогтох)-д даалгасугай.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын  
03...ний өдрийн 35 тогтоолын хавсралт

Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгө худалдах хөрөнгийн жагсаалт

№	Барилга, байгууламжийн нэр	зориулалт	Хэмжих нэгж			Ашиглалтан д орсон огноо	Ашиглалты н нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдса н элэгдэл	Үлдэгдэл өртөг	Дуудлага худалдаан ы үнэ
			Хэм жих нэгж	Биет хэмж ээ	Ш						
1	Модон склад	склад	ш	7*5	1978-01-01	6	372,494.61	62,082.48	310,412.13	350,000	
2	Хүрэн склад	склад	ш	7*5	1978-01-01	6	219,377.83	36,562.92	182,814.91	350,000	
3	Аж ахуйн хашаа	склад	ш		1978-01-01	4	276,760.25	69,190.08	207,570.17	250,000	
<b>Нийт дүн</b>											
							<b>868,632.69</b> /найм зуун жаран найман мянга зургаан зуун гучин хоёр төгрөг жаран есөн мөнгө/	<b>167,835.48</b> /нэг зуун жаран долоон мянга найман зуун гучин таван төгрөг дөчин найман мөнгө/	<b>700,797.21</b> /долоон зуун мянга долоон зуун ерэн долоон төгрөг хорин нэгэн мөнгө/	<b>950,000</b> /есөн зуун тавин мянган төгрөг/	